



**ХЭНГИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар A/08

Дуурлиг

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйл 37.1.7 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2 дахь заалт, 13 дугаар зүйл, 16 дугаар зүйлийг 16.1 дэх хэсэг, Улсын Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг батлах тухай 05 дугаар тогтоол, 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Байгууллагын хамт олны санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Сумын Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Г.Гимаа (Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд: С.Пүрэвцэрэн (Төсвийн ерөнхий Нягтлан бодогч буюу Санхүүгийн албаны дарга)

Г.Жавзмаа (Жаргалант багийн Засаг дарга)


2.Ёс зүйн дэд хорооны дүрмийг хавсралтаар баталж мөрдүүлсүгэй.

3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан журмын хэрэгжилтийг ханган хариуцлагатай ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/05 тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.БАТ-ЭРДЭНЭ



ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ АЖИЛЛАХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулахад оршино.

1.2. Ёс зүйн дэд хороо нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

1.3. Дэд хороо нь хараат бус, ил тод, шударга, хууль дээдлэх, хүний эрхийг хүндэтгэх, нууцлалыг хангах зарчмаар ажиллана.

Хоёр. Бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Дэд хороо нь дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Дэд хорооны дарга үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хуралдааныг даргална.

2.3. Нарийн бичиг хуралдааны бэлтгэл хангаж, баримт бичгийг хөтөлнө.

2.4. Гишүүд асуудлыг хэлэлцэх, санал гаргах, шийдвэр гаргахад оролцоно.

Гурав. Чиг үүрэг

3.1. Ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, сурталчлах.

3.2. Ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг хүлээн авч шийдвэрлэх.

3.3. Урьдчилан сэргийлэх, сургалт зохион байгуулах.

3.4. Зөрчил гаргасан этгээдэд санал, дүгнэлт гаргах.

Дөрөв. Хуралдаан

4.1. Дэд хороо улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

4.2. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдана.

4.3. Олонхийн ирцтэйгээр хурал хүчинтэйд тооцно.

4.4. Шийдвэрийг олонхийн саналаар гаргана.

Тав. Өргөдөл, гомдол шийдвэрлэх

5.1. Гомдлыг бичгээр, цахимаар болон амаар хүлээн авна.

5.2. Хуулийн хугацаанд шалгаж шийдвэрлэж, шилжүүлнэ.

5.3. Шаардлагатай бол хугацааг сунгаж болно.

5.4. Гомдол гаргагчийн мэдээллийг нууцална.

Зургаа. Хяналт

6.1. Дэд хорооны үйл ажиллагаанд удирдлага хяналт тавина.

6.2. Шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллана.

6.3. Жил бүр тайлан гаргана.

Долоо. Бусад

7.1. Энэхүү дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

7.2. Дүрэм батлагдсан өдрөөс эхлэн мөрдөгдөнө.